

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-26
<hr/>	
1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-9
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	9-14
3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	14-19
4. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	19-19
5. Төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг сонсох	19-26

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 17-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, С.Ганбаатар, Б.Пүрэвдорж;
Чөлөөтэй: Ж.Батсуурь, Б.Жавхлан, Д.Өнөрболор, Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны
өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Рэнцэнбазар, Н.Ууганбаатар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Т.Мөнхцэцэг, Бодлого төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Үйлдвэржилт, дэд бүтцийн хэлтсийн дарга Ш.Маргад, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Сонор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмжийн талаарх танилцуулгыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар танилцуулав.

Илтгэлтэй болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 9 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Төлөвлөлтийн инженерийн албаны дарга А.Баяржаргал, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Ц.Чинзориг, Газрын тосны хайгуул ашиглалтын газрын дарга Д.Буян-Арвижих нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын дэд даргын зөвлөх П.Батхишиг, Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал О.Сансархүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Тэмүүлэн, *Эрх зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар нар танилцуулав.*

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-г заасны дагуу *Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.23 дахь заалт нэмсүгэй:

38.1.23.оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.19-д” гэсний дараа “38.1.23-г” гэж нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 10 цаг 30 минутад завсарлаж, 19 цаг 12 минутаас үргэлжлэв.

Тав.Төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, мөн газрын Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Захиргаа, хууль, эрх зүйн газрын дарга С.Батбямба, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Чанарын баталгаажуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Батсайхан, Мэдээллийн технологийн төвийн захирал А.Уянга-Эрдэнэ, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын Бодлого, төлөвлөлт хариуцсан менежер Б.Баттуяа, мөн газрын ахлах шинжээч Б.Ариунзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн

Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав, мөн газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг сонслоо.

Уг асуудлыг 19 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 18 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 19 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим 09 цаг 42 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Амартүвшин гишүүн хүрэлцэн ирсэн байна. Булгантуяа гишүүн, Одонтуяа гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Баделхан гишүүн, Хүрэлбаатар гишүүн, Батжаргал гишүүн, Мөнхбаатар гишүүн, Сандаг-Очир гишүүн. Бусад гишүүдийг дуудаарай. Хуралдааны ирцэд орсон гишүүдийг доошоо хуралдааны танхимд орж ирэхийг мэдэгдье.

Ингээд байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

2 дугаарт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, мөн хэлэлцэх эсэх

3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг

4.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг

5.Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамт өргөн мэдүүлсэн 17 хууль, 1 тогтоол, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх байгаа.

6.Аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэх эсэх

7.Байнгын хорооны тогтоол төсөл /Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай/ гэсэн ийм 7 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар сайд танилцуулна. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Ч.Хүрэлбаатар: Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг та бүхэнд танилцуулж байна.

Манай Улсын эдийн засаг ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд 4,6 хувь ажижж байсан бол сүүлийн 2 жилийн хугацаанд 5 хувь болон 7 хувиар тус тус өсөөд байна. Цаашид Оюутолгойн уурхайн олборлолтын хэсэг, зэс, алтны агууламж нэмэгдэж байгаа. Экспортын үйл ажиллагаа сэргээж жигдэрсэн. Аялал жуулчлал, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа идэвхжиж байгаа зэргийн

нөлөөллөөр эдийн засгийн өсөлт эрчимжиж 2025 онд 8 хувь, 2026, 2027 онд тус тус 6,5 хувь орчимд тогтвортой хадгалагдахаар байна.

Мөн цар тахал болон Украйнд болж буй геополитикийн тогтворгүй байдлын нөлөөгөөр 2022 онд 16,9 хувь болж өсөөд байсан инфляц 2024 оны 4 дүгээр сард 6,4 хувь болж буураад байна. Цаашид валютын нөөцийг 10 тэрбум ам.доллар-т хүргэж, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой нэмэгдүүлнэ. Төсөв мөнгөний оновчтой бодлогыг хэрэгжүүлснээр инфляцыг 2025 онд 6 хувь, 2026 онд 4 хувь, 2027 онд 3 хувь хүргэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2025 онд ДНБ-ий 2 хувь, 2026 онд 1,5 хувь, 2027 онд 1 хувьд хүргэж, үе шаттай бууруулах, Засгийн газрын өрийг 2027 онд ДНБ 40 хувиас хэтрүүлэхгүй байхаар хуулийн төсөлд тусгалаа.

Тус хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан нэгдсэн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл болон Засгийн газрын өртэй холбоотой төсвийн тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангасан болно. Уг уулийн төсөлд Төсвийн тухай хуульд заасны дагуу 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог ханган хэлэлцүүлж, холбогдох саналыг тусгасан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хүрэлбаатар сайдад баярлалаа. Ажлын хэсэгт Эдийн засаг,

хөгжлийн яам болоод Сангийн яамны холбогдох албан тушаалтнууд оролцож байна. Та бүхэнд бас нэмэлтээр танилцуулах ажлын хэсэг байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болоод гишүүд хүрэлцэн ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Гангэрэл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Жамсрандоржийн Дэлгэрсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл зөвлөлийн гишүүн Ланганы Отгонтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Равсалын Рэнцэнбазар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Нинжбатын Ууганбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Амаржаргалын Энхбат нар хүрэлцэн ирсэн байна.

Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Энхбаяр танилцуулна. Энхбаяр даргыг микрофонд урьж байна. Ажлын хэсгийн 4 номер.

Н.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өнгөрсөн 2023 оны 7 дугаар сард орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өнгөрсөн 3 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын дунд хугацааны макро эдийн засгийн төсөөллийг боловсруулж, Төсвийн байнгын хороо болон Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн байгаа.

Энэ дээр бол ирэх 2025 он болон 2026, 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад шаардлагатай эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн ерөнхий хязгаарыг боловсруулж хүргүүлсэн. Ингээд одоо өргөн баригдаад байгаа 2025 оны төсвийн хүрээний

мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн хүрээний төсөөлөлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бас холбогдох санал, дүгнэлтээ хуулийн дагуу гаргаж, та бүхэнд хүргүүлсэн байгаа. Цаг богино байгаа учраас би голлох зүйлүүдийг нь товчхон дурдаад явъя.

Одоо өргөн бариад байгаа төсөл дотор зарим бидний өнгөрсөн удаад өгсөн тооцоололтой болон одоогоор бас нөхцөл байдалтай төдийлөн нийцэхгүй байгаа зарим үзүүлэлтүүд байгаа. Тухайлбал эдийн засгийн өсөлтийг 2025 онд 8 хувь, нүүрсний экспортыг энэ 2024 онд 78 сая төг төгрөгт хүргэнэ гэсэн нь бол нэлээн өөдрөг төсөөлөл болжээ гэж бид үзэж байгаа. Яагаад гэхээр дэлхийн эдийн засгийн болон бүс нутгийн нөхцөл байдал бол маш хурдтай өөрчлөгдөж байна. Саяхан бидний авсан одоо судалгаа, тооцоолол, мэдээллээс үзэх юм бол Хятад Улсын нийт нүүрсний экспорт бол 2023 онд бол 474 сая тонн байгаа. Үүнээс коксжих нүүрс нь бол 103 сая тонн байгаа. Тэгэхээр энэ коксжих нүүрсний хэрэглээ цаашидаа өсөх үү гэдэг асуудал дээр бас судлаад үзэхэд одоогоор бол төдийлөн өсөх хандлага харагдахгүй байгаа. Үндсэндээ ойрын жилүүдэд бол энэ хэмжээнээсээ төдийлөн өсөхгүй. Тэгэхээр бидний одоо нийлүүлж байгаа 70 орчим сая тонн нүүрс цаашидаа өсөх орон зай бага байна гэж бид үзэж байгаа.

Нөгөө талаар Монгол Улстай ижил төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж байгаа Австрали Улс ирэх онуудад бол нүүрсний экспорттой 20-25 сая тонн, ОХУ Лкински нүүрсний уурхайгаас шинээр барьж байгаа төмөр зам, далайн боомтоор дамжуулаад мөн 20 сая тонн коксжих нүүрсийг Хятад Улсын зах зээл дээр нийлүүлэх ийм боломж нөхцөл, дэд бүтцийн нөхцөл бүрдсэн байна.

Ийм учраас одоогийн байгаа Монгол Улсын нийлүүлж байгаа үндсэндээ гол зах зээл бол Өвөр

Монголын зах зээл байгаа. Тэгэхээр энэ зах зээл дээр бид нар нийлүүлэх боломж хэр байгаа вэ гэдгийг бид нар маш сайн анхааралтай судалж үзэх ёстой. Энэ өдрүүдэд ОХУ-ын Ерөнхийлөгчийн Хятад Улсад хийсэн айлчлалын хүрээнд 2 улс өчигдөр хамтарсан мэдэгдэл гаргаж байна. 2 улсын хооронд 11 бичиг баримтын гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж байна. Эдгээр бичиг баримт ч гэсэн 2 улсын худалдааг бол цаашид бол улам эрчимжүүлэх зорилт тавигдаж байгаа учраас Монгол Улсын түүхий эдийн экспорт бол ирэх 2025, 2026, 2027 оны хувьд бол маш өрсөлдөөнтэй болох нь гэж бид үзэж байгаа.

Ийнхүү Монгол Улсын эдийн засагт голлон нөлөөлж байгаа нь түүхий эдийн экспортын өсөлтийн хандлагын төсөөллөөс өөр байгаагаас шалтгаалаад ирэх жилүүдийн төсвийн орлого болон зарлагын төсөөлөл дээр бид мөн арай өөр дүгнэлттэй байгаа. Энэ талаар бол танилцуулгадаа та бүхэнд дурдаж хүргэсэн байгаа.

Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн алдагдлын хязгаар бол хуульд нийцсэн байгаа гэдгийг бид дүгнэн хэлж байгаа. Төсвийн ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хэмжээ мөн зохистой түвшинд байна гэж бид үзэж байна. Товчхондоо танилцуулахад ийм айна.

Г.Тэмүүлэн: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Энхбаяр даргад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Тэгэхээр ажлын хэсгийн бүрэлдэхүүн бүгдээрээ бас чуулган танхимд орох байх. Тэгээд чуулган дээр бол Улсын Их Хурлын гишүүд тодорхой асуулт асууж, саналуудаа хэлэх байх. Тэр үед бас та бүхэн маань холбогдох

асуудлууд дээр бас хариулаад яваарай. Ингээд санал хураалтыг явуулж эхэлье.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалтын дүнг танилцуулъя. 80 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаар Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Амартүвшин гишүүн танилцуулах уу. Амартүвшин гишүүн танилцуулна. Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

9.54 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа танилцуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай. Булгантуяа сайд.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн бүтээн байгуулалт 16 хувь, үйлдвэр тос дамжуулах хоолойны угсралтын ажил 39 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн асуудалд Улсын Их Хурал, Засгийн газраас онцгойлон анхаарч, Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолын

газрын тосны хайгуулын давст 31 талбайг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-д олгосон бөгөөд уг талбайг өмнө хийгдсэн хайгуул судалгааны ажлын анхдагч мэдээлэл, геологи, геофизикийн өгөгдөл тайлал хийж, газрын тосны хэтийн төлөвлөлт урьдчилсан байдлаар үнэлгээ хийн ажиллаж байна.

Монгол Улсын газрын тосны олборлолт 2015 онд 1,2 сая орчим тоннд хүрч байсан бол сүүлийн жилүүдэд олборлолтын хэмжээ эрс буурч 2023 онд 600 орчим мянган тонн газрын тос олборлосон. Голлох олборлолтод хийгдэж байгаа Тамсаг, Тосон уулын ордын жилийн олборлолтын хэмжээ 700 мянгаас 400 мянган тонн хүртэл буурах төлөвлөлттэй байгаа нь үйлдвэр ашиглалтад орох үед түүхий эдийн тогтвортой хангамжид эрсдэл үүсэхээр нөхцөл байдалтай байна.

Газрын тосны хайгуул олборлолт нь хөрөнгө оруулалтын зардал ихээхэн шаарддаг эрсдэл өндөртэй үйл ажиллагаа бөгөөд газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн асуудлыг ишийдвэрлэх хүрээнд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэрийн зүгээс Давст 31 талбайд хөрөнгө оруулж хамтран ажиллах тухай урилгыг олон улсын 50 гаруй компанид хүргүүлсэн боловч санал ирүүлээгүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.1-д “албан татвар төлөгчийн дараах орлогын албан татвараас чөлөөлнө.”, 21.1.4-д “газрын тосны салбарт бүтээгдэхүүн авах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт ноогдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн 18.6.2 20.1-д заасан орлого” гэж тус тус заасан байдаг. Одоо энэ хуульд. Үүнд нийцүүлэн Засгийн газраас олгосон Давст 31 талбайд хөрөнгө оруулалт хийж газрын тосны хайгуул ашиглалтад газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-

тай хамтран ажиллах, хөрөнгө оруулагч компанийг Монгол Улсад бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх бодит шаардлага тулгарч байна.

Дээрх хэрэгцээ шаардлагын хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар Давст 31 талбайд хөрөнгө оруулагчтай хамтран хайгуулын ажлыг эрчимтэй явуулж газрын тосны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн тодорхой хэсгийг өөрийн олборлосон газрын тосоор хангахад томоохон дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой гэж салбарын яамнаас үзсэн байна. Ингээд хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье.

Г.Тэмүүлэн: Булгантуяа сайдад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Уул уурхай яамны Хүнд үйлдвэрийн газрын Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн захиргааны газрын дарга Очирын Энхбаяр, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Төлөвлөлтийн инженерийн албаны дарга Амаржаргалын Баяржаргал, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр компанийн Газрын тосны хайгуул ашиглалтын газрын дарга Даваагийн Буян-Арвижсх, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Уранбаатарын Чинзориг гэсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Батжаргал гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Үгүй ээ, нээрээ хонх нь дуугарахаар дамар нь таг гэгчээр нэг арай чүү газрын тосны үйлдвэртэй болох гээд ингээд бүтээн байгуулалтын ажил нь эрчимжээд нохойн дуу ойртоод ирэхээр бүр үндсэн бүтээгдэхүүн нь байхгүй болчих юм. Үйлдвэрлэл нь багасчих юм. Энэ одоо ямар учиртай юм бэ. Өчнөөн олон жил одоо гадагшаа гаргах болохоороо л хэдэн мянган тонноор нь ингээд л гаргаад л байдаг, тэгээд өөрсдөө үйлдвэртэй болъё, дотооддоо хэрэгцээгээ хангая гээд ингээд үйлдвэрлэлтэй болоод ирэхээр үндсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь багаслаа. Энэ ч гаалийн татвар, энэ ч аж ахуйн нэгжийн орлогын татвараас чөлөөлж өг. Үйлдвэрлэлээ нэмэгдүүлье, хайгуулаа нэмэгдүүлье гээд яриад байдаг нь ямар учиртай юм. Үүнийхээ учрыг нь тайлбарлаач. Яагаад үйлдвэрлэл багасах, буурах ийм шалтгаан нөхцөл үүсээд байгаа юм. Заавал ингэж одоо гааль, аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлүүлж байж үйлдвэрлэлээ, хайгуулаа нэмэгдүүлье гэж байгаа юм уу. Үүнийхээ учир шалтгааныг хэлж өгөөч.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Магнайсүрэн дарга 5 номер.

С.Магнайсүрэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Магнайсүрэн. Гишүүний хэлсэн шүүмжлэлтэй бол санал нэг байгаа. Өөрөөр хэлэх юм бол бид нар урьд нь 2015 онд 1,2 сая орчим тонн хүртэл олборлож чадаж байсан бол өнгөрсөн онд буюу 2023 онд бид нар 600 гаруй мянган тонныг л олборлосон. Өөрөөр хэлэх юм бол хагасыг нь л олборлосон гэсэн үг. Үүний учир шалтгаан нь бол өнөөдөр олборлож байгаа компанийн үйл ажиллагаатай

холбоотой ийм асуудлууд байна. Энэ дотроо бол 1 дүгээрт орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа энэ компани орон нутагтайгаа ойлголцохгүй байх нэг ийм асуудлууд байна.

2 дугаарт бас олон нийтийн зүгээс эсэргүүцэж үйл ажиллагаанд нь бас хөндлөнгөөс нөлөөлж байгаа ийм үйлдлүүд нэлээн гол нөлөөлөл болж байгаа. Түүнээс өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа хуультай холбоотой татварын орчны асуудал бол биш юм. Ер нь бол хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх асуудлаар бол ажлын хэсэг гарсан ажиллаж байгаа. Аль болохоор богино хугацаанд ойлголцохоор ишийдэлд бол хүрсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад, урд талын гол хөрөнгө оруулагчтай тохиролцоод ямар ч байсан эхний алхам бол хийгдчихсэн байж байгаа. Өөрөөр хэлбэл Бүтээгдэхүүн хуваах гэрээндээ бол өөрчлөлт шинэчлэлтийг бол хийе гэдэг дээрээ бол тохирсон байж байгаа. Тэгэхээр энэ асуудал бол удахгүй ишийдэгдвэл энэ олборлолтын цар хэмжээ бол хэвийн голдиролдоо орох болов уу гэж үзэж байгаа. Биднээс үл шалтгаалж байгаа нөлөөлж байгаа хөндлөнгийн нөлөөлөл бол энэ буруу мэдээллийн үүднээс эсэргүүцэх, үйл ажиллагааг нь зогсоохтой холбоотой асуудлууд байна. Орон нутагтайгаа ойлголцох бас асуудал байгаа гэж бид нар бол ингэж харж байгаа.

Өнөөдрийн энэ оруулж ирж байгаа хуулийн төсөл бол энэ олборлолттой хамааралгүй, харин ч нэмэгдүүлэхэд чиглэсэн ийм хуулийн төсөл байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Газрын тосны үйлдвэрийг дэмжих тухай хуулиар давуу эрхээр энэ үндэсний үйлдвэртээ газар олгоно. Тэр газар дээрээ гадаадын хөрөнгө оруулалттай хамтарч ажиллах тэр бололцоог нь дэмжих ийм эрх зүйн үндэслэл Их Хурлаас баталчихсан. Энэ хүрээнд энэ Давст 31 гэдэг энэ талбайг болбол

Засгийн газраас 2021 онд газрын тос боловсруулах үйлдвэрт олгочихсон. Тэгээд энэ дээр одоо бид нар 40 гаруй компанийг оруулахаар сонгон шалгаруулалт зарласан боловч өнөөдрийг хүртэл орохгүй байгаа шалтгаан нь Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй адилхан татварын хөнгөлөлт адилхан эдэлбэл орох тэр бололцоо бүрдэх юм байна гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн учраас Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр зөвхөн.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд тодруулъя. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ юу яриад байна. Монгол Улс чинь төрийн бодлого тогтмол нэгдмэл юм байгаа биз дээ. Тэгээд орон нутагтайгаа ойлголцохгүй гээд Монгол төрийн бодлогыг эсэргүүцэж байдаг орон нутаг гэж байдаг юм уу. Орон нутагтай нь ойлголцоно гээд дотоодоосоо өөрсдөө бүтээгдэхүүнээ хангая, газрын тосны үйлдвэрээ байгуулъя гэж байхад эсэргүүцэж байдаг орон нутаг байдаг юм уу. Энэ бодлогыг. Тэгээд яам нь орон нутагтаа ойлголцчихвол гээд ингээд явж байх юм. Үгүй ээ, тэгвэл энэ асуудлыг нь холбогдох хууль хүчний байгууллагаар нь шалгуулаач. Ямар орон нутгийн эрхтэн дархтнууд энэ бодлогыг эсэргүүцээд байдаг юм. Ойлголцохгүй байгаа юм. Тээг, гацаа болоод байдаг юм. Энийг нэг тайлбарлаж өгөөч.

Г.Тэмүүлэн: 5 номер Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Сандаг-Очир гишүүнийг тодруулгад хариулъя. Ер нь бол одоо тэр ойлголцлын асуудал бол бид нар тодорхой түвшинд тавьж байгаа. Жил болгон Ү аймаг, орон нутгийн удирдлагатай гэрээ байгуулах энэ шатдаа ч гэсэн гэрээндээ хүртэл суулгаж өгч байгаа. Тухайлах юм бол саяхан аймгаас шалгалт ороод, тодорхой торгууль, актууд тавиад, үйл ажиллагааг нь зогсоогоод өнөөдрийн

байдлаар бол данс нь хаагдах хүртэл ингээд асуудал хүрчихсэн ингэж яваа. Энийг бол бид нар бүх түвшинд ярьж байгаа учраас шаардлагатай бол танд бид нар нарийвчилсан мэдээлэл бас өгөх ийм бололцоо байгаа. Тэгээд бид нар удахгүй энэ ойлгоцыг бас тодорхой шийдэл, түвшинд хүргэх байх гэж ингэж найдаад ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн асуулт асууя. Баярлалаа.

Ж.Батжаргал: Баталгаат нөөцөө нэмэгдүүлэх асуудал бидэнд чухал байгаад байгаа. Үнэхээрийн. Өмнө нь энэ асуудал бас 2, 3 яригдсан юм. Тэгээд яг тэр яригдаж байх үед одоо гараад байгаа түүхий бүтээгдэхүүний чинь хэмжээ буураад байгаагийн учир шалтгаанаа тодорхойлж тогтоомоор байна гэж.

2 дугаарт нь цаашид үйлдвэр ашиглалтад ороход одоо Монголоос гараад байгаа бүтээгдэхүүн үйлдвэрийнхээ түүхий эдээр орж ирэх тэр тодорхой санамж, гэрээ юмнуудаа байгуулаач гэсэн юм. Тэр асуудал байхгүй л гээд байгаа юм. Яг одоо Бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ үндсэн дээр бол манай өөрийн яах юм нь 20 хэдэн хувь л юм байна лээ шүү дээ наадах чинь. Тэрнээс цаадхаа бол тэр улсууд зах зээлийнхээ ханшаар л юугаар л ярих юм байна лээ шүү дээ. Тэгээд үүнийгээ тодорхой болгож чадсан юм уу, үгүй юм уу гэж 1.

2 дугаарт гаднын мэргэшсэн компаниудтай хамтарч хайгуулын ажил хийе, баталгаат нөөцөө нэмэгдүүлэх ажлаа зохион байгуулъя гэж байгаад би татгалзах юм алга. Энэ зөв.

Гэхдээ тодорхой хэмжээний нөөц юмнууд тогтоогдчихлоо, тэрний ар дээр ямар харилцан эрх ашиг нь хангагдсан байдлаар юмнуудаа зохицуулж гэрээ хэлцлээ хийж байгаа юм гэдэг юм чинь гол байгаад байгаа шүү. Бид нарын ерөөсөө яваад байгаа юмны чинь гол юм

нь нэг юманд очоод жигтэйхэн найр тавиад нэг марзан гэрээ хийчихдэг. Яг цагаа тулаад л ажил эхлэх гэхээр зэрэг нөгөөдхөдөө боогдоод боомилгодоод байдаг байхгүй юу. Тэгээд энэ нь ямархуу юм хийж байгаа юм бэ. Үнэхээрийн бидний үндэсний эрх ашигт нийцтэй юм болж чадаж байгаа юм уу, чадахгүй байгаа юм уу энэ чинь. Үүнийгээ нэг тодорхой тайлбар мэдээлэл авмаар байх юм.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. 5 номер. Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас үйлдвэр ашиглалтад орох үед энэ бүтээгдэхүүн нөөцийг бий болгох талаар, бий болгосон байх талаар, энэ талаар нэлээн анхаарал тавьж ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар манай яаман дээр 3 бүтээгдэхүүн хуваах гэрээ Засгийн газраар ороход бэлэн болсон. 6 Бүтээгдэхүүн хуваах гэрээ Засгийн газрын гишүүдээс санал авах түвшинд явж байгаа. Бид аль болохоор энэ эрэл хайгуулыг бол нэлээн эрчимтэй явуулах нь зүйтэй гэдэг байдлаар явж байгаа. Энэ бол яг өнөөдрийн үйлчилж байгаа хууль, тогтоомжийн хүрээнд сонгон шалгаруулалтаар яваад ингээд гаднын хөрөнгө оруулагчид гэрээгээ тохироод ингэж орж ирж байгаа ийм хэлбэрүүд байгаа. Гол асуудал бидэн дээр юу тулж байгаа вэ гэхээр Петрочайнатай байгуулсан өнөөдрийн үйлчлээд, газрын тос олборлож байгаа энэ компанитай байгуулсан гэрээг шинэчлэхтэй холбоотой асуудал багагүй хугацаанд сунжирч байгаа нь одоо нэг асуудал бий. Ингээд энэ оны сүүлээр Хэрэг эрхлэхийн сайд урд хөршид айлчилж, том хөрөнгө оруулагч, гол хөрөнгө оруулагчаа тохирч 2 талын комиссыг байгуулаад, ингээд нэгдсэн шийдэлд ямар ч байсан шинэчлэх нь зүйтэй юм байна. Өнөөдрийн үйлчилж байгаа хуулиудынх нь хүрээнд шинэчилье. Тэгэхдээ ямар түвшинд хүрэх вэ гэдгээ ярилцъя гэдэг ийм асуудлууд яригдаад нэг

алхам хийгдсэн. Ингээд ажил эхэлсэн нь бол гол асуудал байж байгаа. Дээр нь энэ хүрээнд бол Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэр ашиглалтад орох үед бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахтай холбоотой асуудал нэг гол чиглэл нь болж яваа ийм хэлэлцээрүүд үргэлжилж байгаа. Энэ бол ойрын хугацаанд шийдэгдэх ийм бололцоотой гэж бид нар харж байгаа.

Өнөөдрийн энэ оруулж ирж байгаа хуулийн төсөл болохоор төр өөрөө бүтээгдэхүүн хуваах гэрээ биш, ТӨК гаднын хөрөнгө оруулагчидтай гэрээ хийж, Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй адилхан ийм гэрээ хийж хайгуул хийх ийм асуудлыг нээсэн. Тэр асуудал нь Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй адилхан Татварын эрх зүйн орчинд байх нь зүйтэй юм гэсэн ийм л хуулийн төсөл орж ирж байгаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм ээ тэрийг чинь бол мэдээд байгаа. Хамгийн гол нь үйл ажиллагаа явуулж байгаа компанитай байгуулсан гэрээгээ бид шинэчлэх тухай ярьж байна. Дараагийн тэр бүтээгдэхүүн хуваах гэрээ гэдэг юм уу, эсвэл бүтээгдэхүүн хуваах гэрээтэй ижил маягийн гэрээ байгуулах замаар хайгуулын ажил хийх гээд байгаа компаниудтайгаа хийх гэрээ чинь л тэр шинэчлэх гээд байгаа гэрээнийхээ нөхцөл рүү ойртсон гэдэг юм уу тэрэндээ хүрсэн, үндэснийхээ эрх, ашгийг хангасан байх тухай л асуудал байгаад байгаа юм. Тэгэхгүйгээр 1 марзан гэрээ хийчихдэг, тэрнээсээ болоод дахиад үр дүнгүүд гараад ирэхийн цагт дахиад өөрсдөө боомилогдчихдог ийм л юм л үүсээд байгаа байхгүй юу. Тэгээд үүнийгээ бол нэлээн сайн бодож хийх нь зөв байх гэж би бол ингэж хараад байдаг юм.

Нэг их сонин зүйл байгаад байгаа шүү дээ. Дэлхийн зах зээл дээр нефть бүтээгдэхүүний үнэ нэг хэсэг өссөн.

Тэгээд манайхаас гарч байгаа энэ түүхий бүтээгдэхүүний чинь үнэ хэдий хэмжээний өсөлт аваад.../минут дуусах/

Г.Тэмүүлэн: Магнайсүрэн дарга асуултад хариулъя. 5 номер.

С.Магнайсүрэн: Батжаргал гишүүний ярьж байгаа асуудлыг бол гол үндсэн зарчим болгож ингэж ажиллаж байгаа. Тийм учраас түрүүн би хэлсэн. 3 гэрээ бэлэн болчихсон, 6 гэрээг бэлэн болгоод санал авах түвшинд явж байгаа. Тэгээд энэ маань бас нэг жоохон удаашираад оруулахгүй байгаа нэг үндсэн асуудал нь эхлээд бид нар энэ том гэрээгээ зарчмын хувьд бүх түвшний оролцоотой зарчмаа тогтоож байгаад, түүнийгээ дагуулж бусдыгаа явуулах нь зүйтэй гэдэг байдлаар бас харзнаж удааширсан ийм тал байж байгаа. Ер нь үндэснийхээ эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид тавьж байгаа гэдэг энэ зарчим бол гол хэлэлцээрийн сэдэв болж ингэж явж байгаа гэж ингэж ойлгож болно.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Бүтээгдэхүүн хуваах гэрээний түвшинд очсон юм бол тодорхой нөөц тогтоогдсон гэсэн үг. Мэдээж ойлгомжтой. Тэгэхээр зэрэг нэг томоохон нөөц дээр нь үндэснийхээ эрх, ашигт нийцсэн, одоо тэр бүтээгдэхүүн гаргаад байгаа компанитай байгуулсан гэрээнээс хамаагүй эерэг нөхцөлтэй гэрээ байгуулчихмаар байгаа юм. Бид бусадтай ингээд хийсэн. Одоо танайтай гэрээгээ шинэчилнэ гэдэг юмаа ярих ёстой байхгүй юу. Тэгэхгүй тэр цаадахтай гэрээгээ шинэчилж байж бусдадаа тийм загвараар явна гэвэл зөндөө удна. Цаг хугацаа алдана. Тийм учраас бид хамгийн гол бодох ёстой зүйл бол ижил төстэй үйл ажиллагаатай нөөц нь тогтоогдчихсон газар дээрээ үнэхээрийн сайн гэрээ хийж чадах юм бол яг тэр гэрээнийхээ загвараар нөхцөлөөр одоо гэрээ байгуулаад явж байгаа үйл ажиллагаа явуулж байгаа

этгээдтэйгээ гэрээгээ байгуулах тухай шинэчлэх тухай асуудлыг хүчтэй ярих бололцоо.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 5 номер.
Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Өнөөдрийн эрх авчихсан буюу эрэл хайгуул хийж байгаа энэ Бүтээгдэхүүн хуваах гэрээ хийчихсэн, Засгаар оруулаад шийдүүлэх гэж байгаа энэ бүх асуудал дээр яг нөөц нь тийм гээд тогтоогдчихсон зүйл бол байхгүй. Өөрөөр хэлэх юм бол нөөц байж болзошгүй гээд эрэл хайгуулын түвшинд л бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад орж байгаа юм. Яг нөөц нь тогтоогдоод ингээд орчихсон тийм юу бол одоо өнөөдрийн анхны энэ олборлож байгаа Петрочайна компанитай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ, бусад нь бол нөөц тогтоогдвол ингэнэ гэдэг байдлаар л бүтээгдэхүүн хуваах гэрээ адилхан хийгдэж байгаа. Газрын тосны хууль нь ч ийм. Тийм учраас бид нар түрүүлээд ийм байна гэж хийхэд их төвөгтэй. Хөрөнгө оруулагч нар бол 100 хувь хөрөнгөө эрсдэлээ өөрөө дааж орж байгаа учраас хуульд заагдсан хэмжээнд эхний ээлжид хийгээд л бүтээгдэхүүн хуваах гэрээний төслүүд бий болоод явж байгаа. Тэгээд одоо бид нарын гол хэлээд байгаа юм бол энэ нөөц нь тогтоогдоод олборлож байгаа энэ компанитай байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчмыг бас нэлээн харзнаж байгаа ийм л нөхцөл байдал байж байгаа.

Г.Тэмүүлэн: Магнайсүрэн даргад баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ерөнхийдөө зарчим нь бол яах вэ бид нар 2021 онд Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийг баталсан. Тэр хуулийнхаа дагуу өөрсдөө эрэл хайгуул хийх эрхийг нь нээж өгсөн. Тухайн тэр газрын тосны түүхий тосныхоо эх үүсвэрийн нөөцийг найдвартай бөгөөд хангамжийг бүрдүүлэх үүднээс эрхийг нь нээж өгсөн. Өөрсдөө эрхийг нь нээгээд, тэгээд явъя гэхээр ерөнхийдөө Аж ахуйн нэгжийн

орлогын албан татвартай холбоотой хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудлыг бас хүсээд байгаа. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу адил нөхцөлийг бид нарт бүрдүүлж өгөөч. Тэгвэл бид нар өөрсдөө эрэл хайгуулаа хийгээд, энэ дээр магадгүй тодорхой хөрөнгө оруулалтыг татаад ингээд ямар нэг шинэ компани байгуулахгүйгээр газрын тос боловсруулах үйлдвэр маань өөрсдөө эрэл хайгуулаа хийгээд явъя л гэсэн ийм суурь зарчмаар орж ирж байгаа юм байна. Тэгэхээр яах вэ, бас гишүүдийн хэлж байгаа саналыг та бүх бас анхаарч үзээрэй. Магадгүй нэмэлт хөрөнгө оруулагч орж ирээд өөрсдөө эрэл хайгуул хийхдээ ямар ч тохиолдолд өөрсдийн давуу тал, эрх ашиг бүх зүйлийг бол бий болгож, өмнөх алдаа байр суурь юмнуудыг бол давтахгүй байх ёстой шүү л гэдэг суурь зарчмыг хэлээд байгаа шүү.

Хуулийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Санал хураалтыг явуулж эхэлье.

Та бүхэн маань болж өгвөл тодорхой бас мэдээллүүдээ нэмээд гишүүдэд чуулганаас өмнө өгөөрэй л гэж бас хэлэх байна. Санал хураалт. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төсөлд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулж байна. 63,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Баделхан гишүүн та танилцуулах уу. Баделхан гишүүн танилцуулъя. Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

10.15 цаг.

3 дахь асуудал руугаа оръё.
Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцье.

Төсвийн байнгын хороо 4 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар эрх зүйн дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн байгаа. Эрх зүйн дүгнэлтийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Болдбаатар дарга танилцуулна. Болдбаатар даргыг микрофонд урьж байна. Ажлын хэсгийн 5 номер.

Б.Болдбаатар: Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Манай Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс гаргасан эрх зүйн дүгнэлтийг уншиж танилцуулъя.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 2024/1 Улаанбаатар хот

Эрх зүйн дүгнэлт гаргах үндэслэл.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын гишүүдээс 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар эрх зүйн дүгнэлт гаргуулахаар Төсвийн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаас шийдвэрлэсэн. Тус байнгын хорооноос Улсын Их Хурлын Тамгын газарт 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн УИХ-11/3199 дугаартай албан бичгийг үндэслэн энэхүү дүгнэлтийг гаргав.

Эрх зүйн дүгнэлт гаргахдаа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4.23 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйл, Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 06

дугаар тоот тогтоолоор баталсан “Хууль зүйн дүгнэлт гаргах журам”-д заасныг баримтлав.

Эрх зүйн дүгнэлт гаргах хүрээ, хязгаар.

Эрх зүйн дүгнэлт гаргахдаа Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцэж байгаа эсэх талаар дүн шинжилгээ хийх тухай Төсвийн байнгын хорооноос өгсөн чиглэлийг үндэслэл болгосон болно.

Нэг.Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх талаар:

Хуулийн төсөлд оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортлож байгаа /дотоодод үйлдвэрлэдгээс бусад/ түүхий эд үндсэн ба туслах материалыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр, уг барааны жагсаалтыг Засгийн газар батлахаар тусгажээ.

Монгол Улс 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдөр нэгдэн орсон ДХБ-ын “Тариф худалдааны тухай” 1994 оны ерөнхий хэлэлцээрийн 1А хавсралт болох “Бараа худалдааны тухай” олон талт хэлэлцээрүүдийн “Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай” хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн /с/-д ДХБ-ын тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 121 дэх сарын эхний өдөр сүлжмэл болон оёмол бүтээгдэхүүний салбар нь бүхэлдээ 1994 оны Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд нэгтгэгдсэн байх бөгөөд мөрдөж байсан бүх хязгаарлалтыг энэхүү хэлэлцээрийн дагуу арилгахаар заасан байна.

Монгол Улсын үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль

хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж, Гаалийн тариф гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-д “гаалийн татвараас чөлөөлөх харьцааг гагцхүү энэ хуулиар зохицуулна” гэж заасан.

Дээр дурдсанчлан Монгол Улсын олон улсын гэрээнд оёмол бүтээгдэхүүний салбар дахь бүх хязгаарлалтыг арилгахаар заасан, түүнчлэн хуулийн төсөлд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах хэлбэрээр боловсруулагдсан байх тул Үндсэн хуульд нийцэж байна гэж үзэж байна.

2.Бусад хуультай нийцсэн эсэх, хууль хэрэгжих боломжийн талаар:

1/”Тариф худалдааны тухай” 1994 оны Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд баталсан сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлж, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг Улсын Их Хурлаас 2005 оны 3 дугаар сарын 18-ны өдөр баталсан байх бөгөөд оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортлож байгаа сэлбэг, түүхий эд, үндсэн болон тусгах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас байнгын үйлчлэх шинжтэй буюу тодорхой хугацаа заалгүй чөлөөлсөн байна.

2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр баталсан гаалийн татвартай холбоотой суурь харилцааг зохицуулж байгаа Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-д гаалийн татвараас чөлөөлөх харилцааг гагцхүү энэ хуулиар зохицуулна гэж заасан. Тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын

тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.10-д заасны дагуу хуулийн төсөлтэй хамт бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон Хууль хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулсан байх шаардлага тавигддаг. Гэтэл Гаалийн тариф гаалийн татварын тухай хуулийг баталсантай холбогдуулан өмнө нь үйлчилж байсан 2005 оны Гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгоогүйгээс уг хууль одоог хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна. Гэвч уг хуулийн дагуу чөлөөлөх барааны жагсаалтыг батлах эрхийг холбогдох этгээдэд олгоогүйтэй холбоотойгоор Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсноос хойш буюу 2016 оноос хойш хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсжээ.

2/Хууль санаачлагч Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай 2005 оны хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг өргөн мэдээлээгүй байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.3-д заасны дагуу хууль санаач санаачлагчийн өргөн мэдүүлээгүй хуульд өөрчлөлт оруулахыг хориглох тул Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлаас 2005 оны Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг шууд хүчингүй болгох боломжгүй юм. Иймд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг батлах тохиолдолд хууль хоорондын нийцлийг хангах, давхардал, зөрчлийг арилгах үүднээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэн холбогдох хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгөх агуулга бүхий Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолын төслийг

боловсруулж, хэлэлцүүлэх боломжтой гэж үзэж байна.

3/Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх гэж, Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна гэж заасан. Хуулийг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр төсөлд тусгасан нь уг хуулийн төслийг баталсан тохиолдолд төсвийн орлогын бууралтыг дараа жилийн төсвийн тооцоололд оруулж тооцох боломжийг олгож байх тул хуулийн төслийг төсвийн харилцааг зохицуулж байгаа хуульд нийцэн хэрэгжих боломжтой гэж үзэх үндэслэлтэй байна.

4/Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д заасан хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хэлбэртэй буюу хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-д заасан хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарт багтаан хуулийн төслийг боловсруулсан байна.

5.Гаалийн татвараас чөлөөлөх барааны нарийвчилсан код бүхий жагсаалтыг Засгийн газар батлах тухай зохицуулалтыг төсөлд тусгасан нь хуулийн хэрэгжилтийг хангах гол нөхцөлийг бүрдүүлж байна.

Дүгнэх нь:

1.Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа түүхий эд, үндсэн ба туслах материалыг гаалийн албан татвараас чөлөөлөхтэй холбогдсон харилцааг

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах хэлбэрээр зохицуулах нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байна. Харин хуулийн төсөлд зөвхөн оёмол бүтээгдэхүүнийг хамааруулсан нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт нөлөөлөх эсэх, уг хуулиар зохицуулах харилцааг бүрэн хамарч байгаа эсэхийг сайтар нягтлах шаардлагатай байна.

2.Хууль хоорондын нийцлийг хангах, давхардал, зөрчлийг арилгах үүднээс Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2005 онд баталсан Гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгөх нь зүйтэй байна.

3.Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хууль, тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан хууль зүйн техникийн шаардлагад нийцүүлэх нь зүйтэй.

Г.Тэмүүлэн: Болдбаатар даргад баярлалаа. Эрх зүйн дүгнэлттэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг чуулганд, Байнгын хороонд бэлтгэх ажлын хэсгийг байгуулсан. Миний бие ахлагчаар ажилласан. Пүрэвдорж, Булгантуяа нар ажилласан байгаа. Ажлын хэсгийн танилцуулгыг та бүхэнд бас товч танилцуулъя.

Ингээд ажлын хэсгийн хуралдаан хуралдаж, Тамгын газраас ирүүлсэн эрх зүйн дүгнэлтийг бас хэлэлцсэн байгаа. Ингээд Гаалийн тариф, гаалийн

татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай төслийн талаар эрх зүйн дүгнэлтэд дурдсан энэ асуудлуудыг бас харгалзаж үзээд, хууль хоорондын нийцлийг хангах зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт батлуулах “Засгийн газарт чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж батлуулах нь зүйтэй гэж ажлын хэсэг үзсэн. Үүнд:

1 дүгээрт Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлд Улсын Их Хурлаас 2005 онд баталсан Гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлэх, мөн төслийн 2 дугаар зүйлд Монгол Улсын нэгдэн орсон Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүн тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн С-д сүлжмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний салбар нь бүхэлдээ 1994 оны та Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд нэгтгэгдсэн байх бөгөөд мөрдөж байсан бүх хязгаарлалтыг энэхүү хэлэлцээрийн дагуу арилгах гэж заасантай нийцүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2008 онд баталсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд 2024 оны 10 дугаар дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлэх чиглэлийг өгсөн. Ингээд төсөлтэй холбогдуулж ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй 2 саналын томъёолол болон Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан бэлтгэснийг та бүхэнд тараасан байгаа. Ингээд анхаарал тавьсанд гишүүддээ баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр санал

хураалтыг явуулж эхэлье. Хуулийн төсөл 3 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, санал асуух гишүүн байна уу. Алга байна ажлын хэсгийн 1 санал хураалт байна. Ажлын хэсгийн саналыг уншъя.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.23 дахь заалт нэмсүгэй:

38.1.23.оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, Булгантуяа, Пүрэвдорж “Ажлын хэсэг”. Санал хураалт. Санал хураалт 72,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр холбогдуулж асуулт асуух саналтай гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийн 1 саналаар санал хураалтыг явуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.19-д” гэсний дараа “38.1.23-т” гэж нэмсүгэй. Ажлын хэсэг. Санал хураалт. 72.7 хувиар дэмжигдлээ.

3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж санал хэлэх гишүүн байна уу. Алга байна. Санал хураалтыг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг

нэгдсэн хуралдаанд хэн танилцуулах вэ. Одонтуяа гишүүн танилцуулах уу. Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Ингээд хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

10.29 цаг.

Дараагийн асуудал. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөл дэмжиж тусган хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт гэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн бусад асуудлуудыг нэгдсэн чуулган завсарлахаар үдээс хойш дундуур нь 13 цагаас хуралдъя. Ирцийг бүтэн байлгаж байгаарай.

ЗАВСАРЛАГА.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлье.

Төрийн Аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын ерөнхий аудитын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч Загджав танилцуулна. Таныг микрофонд урьж байна. 4 номер.

Д.Загджав: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Та бүхний энэ үдшийн амар амгаланг айлтгая.

Төрийн аудитын тухай хуульд заасан нээлттэй, ил тод байх зарчмын дагуу Төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэж, үр дүнг та бүхэнд хураангуйлан танилцуулж байна.

Манай байгууллага 2023 онд аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах зорилтын хүрээнд гүйцэтгэсэн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хууль, эрх зүйн өөрчлөлт хийсэн, өмнөх онуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж тайлагнасан, аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, нэгтгэх, модуль системийг нэвтрүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлээ.

2023 он оны тайлант хугацаанд нийт 4 тэрбум 4134 санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитыг гүйцэтгэн 17,6 их наяд төгрөгийн зөрчлийг илрүүлж, холбогдох аудитын шийдвэрийг шалгуулагч этгээдэд хүргүүлснээр улс орон нутгийн төсөвт 51,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж шалгагдагч шалгагдагч этгээдэд 1,1 их наяд төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн нь төрийн аудитын байгууллагын төсвөөс авсан нэгж төгрөгийн санхүүжилт тутамд 38,4 төгрөг төгрөгийн үр өгөөж бий болгосон дүн үзүүлэлттэй байна.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитор бүх шатын төсөвт байгууллага, төрийн

болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан дахь нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 6,7 их наяд төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү, сахилга хариуцлагыг сайжруулж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөх чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллалаа.

Өнгөрсөн онд гүйцэтгэсэн аудитаар 9949 зөвлөмжийн 83,4 хувь, сахилгын шийтгэл ноогдуулах 356 албан шаардлага хүргүүлсний 73,8 хувь нь хэрэгжсэн. Гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 25 асуудлыг Монгол Улсын ерөнхий прокурорт шилжүүлсэн.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд судалгаа хийж, дүрэм журмуудыг хууль тогтоомжуудтай нийцүүлэх, шинэчлэх, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон тайлант хугацаанд 1 эрх зүйн баримт бичгийн 11 эрх зүйн баримт бичгийг сайжруулах болон шинэчлэн боловсруулан батлан мөрдсөн байна.

Төрийн аудитын байгууллага алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийнхээ хүрээнд тодорхойлсон баримтлах чиглэл, бодлогыг хэрэгжүүлэх, албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг чадавхжуулах, тэднийг бүхий л талаар дэмжих сургалт, хөгжлийн стратегийг батлан хэрэгжүүллээ. Байгууллагын манлайллын нэмэгдүүлэх чанарын удирдлагыг төлөвшүүлэх, харилцагч талуудын харилцааг бүхий л түвшинд сайжруулж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийх тогтолцоог төлөвшүүлэх зорилгоор Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо ISO 9001/2015 стандартыг нэвтрүүллээ. Бид хуулиар хүлээсэн төрийн санхүү төсвийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд стратегийн баримт бичгүүдийн

хэрэгжилт тайлант онд дэвшүүлсэн зорилт, аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх, цаашид Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн шинэчлэлт өөрчлөлттэй холбогдуулан төсвийн үр ашигтай, зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, түүнийг төлөвшүүлэхэд хариуцлагаа улам сайжруулж иргэдийн амьдрал, нийгмийн хөгжилд дэмжлэг болгохуйц тодорхой зорилтуудыг төлөвлөн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэн хүргүүлсэн бөгөөд Байнгын хорооноос өгсөн санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан Загджав даргад баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрсийг авчраарай.

Юуны өмнө би бас онцлоод хэлье. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлантай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Сандаг-Очир гишүүнээр тасалъя.

Өмнө нь ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Монгол Улсын ерөнхий аудитын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Дэлэгийн Загджав, Үндэсний аудитын газрын Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Захиргаа, хууль, эрх зүйн газрын дарга Сайнбаярын Батбямба, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Буянтогтохын Бундхорол, Үндэсний аудитын газрын

Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Ядамын Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүүнийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Үндэсний аудитын газрын Чанарын баталгаажуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Жамсрангийн Батсайхан, Үндэсний аудитын газрын Мэдээллийн технологийн төвийн захирал Арсланбаатарын Уянга-Эрдэнэ, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын Бодлого төлөвлөлт хариуцсан менежер Буяндэлгэрийн Баттуяа, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын Бодлого хариуцсан ахлах шинжээч Батсуурийн Ариунзаяа.

Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Жил бүр Үндэсний аудитын байгууллагын тайланг ингэж сонсдог. Энэ ингээд сонсож байна. Тэгээд нөгөө л гардаг нийтлэг зөрчил дутагдлууд, санхүүгийн зөрчил дутагдлууд, акт юмнууд гарсан хэвээрээ л байна даа. Өмнөх жилтэйгээ харьцуулахад улсын хэмжээнд 6 гаруй их наядын санхүүгийн зөрчил гарсан жишээтэй байна. Энэ орон нутгийн байгууллага, төрийн албан хаагчид, байгууллагын дарга нартай уулзахад энэ төрийн хэмнэлтийн хууль баталсан. Төрийн хэмнэлтийн хууль ер нь бас их төрийн байгууллагуудад үйл ажиллагаа явуулахад их хүндрэлтэй байдлыг бий болгосон хэвээр байна гэдэг асуудлуудыг их ярих юм. Энэ аудитын хяналт шалгалтад төрийн хэмнэлтийн хуулийн чиглэлээр акт, зөрчил яг төрийн хэмнэлтийн хуулийг зөрчиж тогтоогдсон акт зөрчил юу байна. Тэгээд цаашидаа ерөнхийдөө бид нар бол эдийн засаг төсөв санхүү 2020, 202, 2022 онд их хүндрэлтэй байсантай

холбогдуулж гаргасан хууль шүү дээ. Ер нь бол. Төсөв, санхүүгийн бүсээ чангалчихсан, хэмнэлтийн горимд шилжих ёстой. Орлого багатай байсан. Тийм учраас зардлаа хэмнэе. Төр өөрөөсөө зардлаа хэмнэе гэдэг үүднээс төрийн хэмнэлтийн хуулийг баталж байсан. Одоо бас яах вэ, нэг үеэ бодоход бас эдийн засаг гайгүй болж байна, өсөж байна, орлого нэмэгдэж байна. Үүнтэй холбогдуулаад ер нь төрийн хэмнэлтийн хуулийг цаашидаа жоохон сулруулах зүйл байна уу. Танай аудитын шинжээч нар, шалгагч нар энэ дээр мэдээлэл өгөөч.

Төрийн байгууллагууд, төсвийн байгууллагууд уралдаан тэмцээн, тавилга, эд хогшил, томилолт, унааны зардал гээд бүх юмыг нь танасан байгаа. Тэгээд одоо энэ дээр гарсан зөрчил дутагдлууд ямар байна. Үргэлжилсэн хэвээр байна уу. Тэгээд цаашидаа энийг жоохон уян хатан сулруулж өгөхгүй бол эргээд нөгөө төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдаад байна гэдэг асуудлыг яриад байгаа шүү дээ. Төрийн байгууллагуудын удирдлагуудын зүгээс. Тэгээд сая Улсын Их Хурлаар хавар хэмнэлтийн хуулийн зарим зүйл заалтыг өөрчилж, уян хатан болгож, орон нутгийн Засаг даргын эрхлэх асуудлын байгууллагуудын машин тэрэг унаа унахыг нь бас жоохон нээж өгсөн. Энэ чинь бас амьдралтайгаа бас ингээд чанга үед нь чанга байх ёстой, төсөв хүнд үед нь чангалах ёстой юм байна гээд. Тэгээд жоохон гайгүй болох үеэр нь бас жоохон сулруулах хэрэгцээ шаардлага байна л гэж байгаа юм. Байгууллагуудын зүгээс. Энэ дээр та бүхэн бас юу хэлмээр байна. Цаашидаа энэ дээр бас Улсын Их Хурал ахиж эргэж авч хэлэлцэх шаардлага хэрэгцээ байна уу, үгүй юу. Төрийн хэмнэлтийн хуулиар. Энэ дээр та бүхэн маань нэг хариулт өгөөч. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 3 номер. 3 номер уу, 4 номер уу. 4 номер Загджав дарга.

Д.Загджав: Төрийн аудитын байгууллага хуулиар хүлээсэн төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийн хяналтыг мэдээж төлөвлөлт, ашиглалт, гүйцэтгэлийн бүх шатад тавьж байгаа. Тэгэхээрээ сая бол дэлхий нийтийг хамарсан ковид цар тахлын тэр хүнд үеүдэд бас улс орнууд ийм арвилан хэмнэлтийн горимд шилжиж ажиллаж байсан цаг хугацааны түвшинд төрийн хэмнэлтийн хууль бас хэрэгжээд бас үр дүнгээ өгсөн гэж бид ойлгож байгаа. Зүгээр ерөнхийдөө улс орны хэмжээнд мэдээж төсөв, санхүүгийн асуудлаар манай аудитын байгууллага ажиллаад, тайлантай танилцаад, төсөв захирагч нартай уулзаад, бас төрийн албан хаагчтай хаагч нартай ярилцаад, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудтай тайлан баланс нийлээд ингээд явж байхад яг таны хэлж байгаа энэ зүйл бол бас гарч байгаа юм. Тийм болохоор бас Их Хурал амьдрал нийгмийнхээ өөрчлөлттэй уялдуулаад бас хууль, эрх зүйн зарим ийм өөрчлөлтүүд хийгээд явахад бас болохгүй байх газаргүй. Ер нь бол ийм шаардлага бас байгаа. Энэ дээр бас Сандаг-Очир гишүүн олж харж асуудал хөндөж байна аа гэж ойлгож байна. Тэгээд бид бүхэн бас тантай санал нэг байгаа. Нэмээд манай Санхүү-нийцлийн аудитын газрын тэргүүлэх аудитор, манай гавьяат Наранчимэг хариулна.

Г.Тэмүүлэн: 3 номер Наранчимэг дарга.

Ц.Наранчимэг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар бид 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Улсын Их Хуралд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн төсөвт байгууллага хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа заалтуудаар нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зөвлөмжийг Улсын Их Хуралд толилуулсан. Тэрний дагуу бол бас төрийн хэмнэлтийн тухай хуульд зарим нэг заалтуудыг тодорхой болгож

өгсөн. Жишээлбэл одоо сургалт зохион байгуулах, машин унаа хэрэглэх албан тушаалтан ч гэдэг юм уу тэрний дагуу энэ жилийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар бол Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн зөрчил багассан.

2022 оны өнөөдрийн хэлэлцэж байгаа тайлангаар бид 61,6 тэрбум төгрөгийн зөвхөн Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоо зөрчлийг илрүүлсэн байгаа. Тэгэхээр Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтуудаар тусгайлан Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэг дэд бүлэг болгож Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг оруулж өргөн барьж байгаа. Таны хэлсэн санал дээр төрийн аудитын байгууллагын аудит хийж байгаа хүмүүсийн гаргаж илрүүлж байгаа энэ хүндрэлүүд яг санал нэг байгаа. Дээрээс нь бид төсвийн төлөвлөлтийг Төрийн хэмнэлтийн тухай хуулиасаа илүүгээр төлөвлөлтөө зөв болгох асуудал дээр төрийн аудитын байгууллага бас удаа дараагийн зөвлөмжүүдийг өгч байна. Мөн энэ олон илрээд байгаа албан шаардлагууд хэрэгжүүлж болохгүй байгаа энэ олон авлагуудыг барагдуулахын тулд энэ жилээс эхлээд бид нар тодорхой хэмжээний удаан жилийн хэрэгжүүлэх шаардлагатай албан шаардлагуудаа бас хувьчилж өгч байгаа. Хувиар. Энэ жил та нар энэ зөрчлийн 20 хувийг заавал арилгасан бай гэсэн ийм албан шаардлагуудыг өгч байгаа.

2 дахид нь зөрчил багасгахын тулд дотоод аудитын эрх зүйн орчныг батлах зайлигүй шаардлага байгаад байгаа. Өнөөдөр Монгол Улсад дотоод аудит маань хуульгүй явж байгаа. Тийм учраас дотоод аудитыг хуультай болгож, энэ төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах бол зайлигүй шаардлага байна гэж төрийн аудитын байгууллагаас үзэж, Улсын Их Хуралд

энэ хуулийг батлахыг бас толилуулсан байгаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Ойлголоо. Ерөнхийдөө бас төрийн хэмнэлтийн хуулийн чиглэлээр 61 тэрбум төгрөгийн зөрчил гарсан гэж байгаа юм байна. Ер нь ингээд та нар маань төрийн аудитынхан маань цөөхүүлээ. Тэгээд асар их материал дээр олон байгууллагуудыг л шалгадаг юм байна лээ л дээ. Ажлын ачаалал их. Тэгээд ингээд өчнөөн олон хоног, өчнөөн цаг, өчнөөн зардал гаргаж ингэж хийсэн дүгнэлтүүдийг, акт, шаардлагуудыг ер нь энэ төрийн байгууллагууд, тэр дундаа Засгийн газар, яамнууд чинь ер нь яг хэрхэн яаж хүлээж авдаг юм бэ. Хэр ач холбогдол өгдөг юм бэ. Би бол харах нь ээ бол нэг л их ач холбогдол өгөхгүй үл ойшоосон шинжтэй, ингээд л нэг тайланг нь ч сонссон нэр төдий, акт шаардлага юмнуудыг ч нэр төдий ингээд л яваад байдаг. Жил болгон л зөрчлүүд гарсан л байдаг. Зөвлөмж өгч л байдаг. Дараа жил ахиад л.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн минутыг нэмье.

Ц.Сандаг-Очир: Тийм учраас би юу хэлэх гээд байна вэ гэвэл цаашидаа ер нь ингээд яваад байх юм уу. Тэгэхээр энэ хууль юмаа жоохон чангаруулж, хариуцлагын асуудлыг нь жоохон чангаруулж, энэ төрийн аудит нарын тавьсан энэ акт, зөвлөмжүүдийг хэрэгжүүлдэг байх тал дээр нь, заавал хэрэгжүүлдэг байх тал дээр нь нөгөө талаар хэрэгжүүлэхгүй байгаа тэр субъектүүдэд төсвийн ерөнхийлөн захирагч нарт хариуцлагын асуудлыг нэлээн өндөр хэмжээнд тавьдаг байх чиглэлээр энэ хуулийнхаа хариуцлагын асуудлыг дээшлүүлэх, чангаруулах тал дээрээ бас шинэ дарга Загджав дарга юу бодож байна вэ. Цаашидаа ингэхгүй юм уу. Тэгэхгүй бол ингээд нөхцөл байдал яг л

жил болгон давтагдаад л, өчнөөн олон хоног, өчнөөн зардал хийж дүгнэлт гаргасан энэ зөвлөмжийг ач холбогдол өгөхгүй үүнд ач холбогдол өгөхгүй, ойшоож анзаарахгүй, хэрэгжүүлэхгүй болохоор чинь ер нь аудит байх шаардлага байна уу гэдэг хүртэл асуудал дээр тулж байна шүү дээ. Тэгэхээр үнэхээр энэ төрийн татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтай төлөвлөхөөс авхуулаад хэрэгжүүлэх зарцуулах хүртэл энэ өмчийн ашиглалтыг зарцуулах хүртэл энэ бүх шатын үйл ажиллагааг хийж байгаа. Тэгээд эндээс зөвлөмж өгч байгаа энэ чиглэлийн ажлыг эрчимжүүлэхгүй бол энэ төсвийн захирагч нар чинь үнэхээр ингээд нэг л их дутуу үнэ цэн, ач холбогдлыг нь дутуу ойлгодог, цаашидаа ач холбогдол бага өгдөг авах арга хэмжээ нь тодорхой бус байна л гэж би хэлэх гээд байна. Тийм учраас цаашидаа энэ хуульд хариуцлагын асуудлыг яаж чангалах вэ, сайжруулах вэ гэдэг тал дээр та бүхэн маань бас ийм хэрэгцээ шаардлага байна уу, үгүй юу гэдгийг та нар маань нэг тодруулж тайлбар хэлж өгөөч.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад нэмж хариулъя. 4 номер уу. Загджав дарга.

Д.Загджав: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллагаас төрийн төсөв, санхүүгийн, нийтийн өмчийн хяналтыг хараат бусаар хуульд заагдсан хэмжээнд тавиад явж байгаа. Бидний хувьд бол яах вэ, хийсэн ажлынхаа үр дүнд төрөл бүрийн шийдвэрийг гаргаж байгаа. Мэдээж аудитын дүгнэлт гаргана. Энэ нь бол ер нь ямар нэгэн тийм өөрчлөх дүгнэлт хязгаартай, хязгааргүй гээд бас зарим зүйлүүд дээр нь бид нар бас дүгнэлт өгөхөөс ч хүртэл татгалзах ийм асуудлууд байдаг. Энэ аудитын шалгалтын үр дүнд бол бид акт, шаардлага, зөвлөмж гаргаж мэдээж төсвийн бүх шатны захирагч нарт хүргэж байгаа. Аудитад тавигдсан актууд бол заавал хэрэгжих хуультай.

Энэ үндсэндээ бол хэрэгжээд явж байгаа. Зарим нэг анхаарал татсан олон улсын.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Загджав дарга гүйцээгээд хариулъя. Минут нэмье.

Д.Загджав: Зарим төрлийн гэрээ конвенцод хамрагдсан зүйлүүд дээр бас биелэгдэхгүй зүйлүүд байна. Таны хэлж байгаа асуудал бол зөв зүйтэй. Мэдээж энд төрийн аудитын болон тангараг өргөсөн алба хаагчид чөмгөө дундартал зүтгэж байгаа. Шөнө, өдөргүй сууж байгаа. Олон газруудад бага нөөц, хүн хүчээр бид бүхэн бас энэ төсвийн хараа хяналтыг сайжруулж, түүний төлөө махийтлаа л ажиллаж байгаа. Энд ажиллаад 4 сарын хугацаа өнгөрч байна. Ингэж байхад энэ бүх аудитынхаа ажлын жаргал зовлонг бүгдийг нь мэдэрч ингэж явж байгаа. Өмнө нь төсөв захирагч байсан болохоос биш яг энэ төсвийн хяналтыг нь хэрэгжүүлж байсангүй. Яг амьдрал дунд нь ороод харахаар бол та бас төсөв захирагч, төсвийн ерөнхийлөн захирагч байсан хүний хувьд бол олж харж байна. Яг энийг бас дэмжээд цааш нь хууль, эрх зүйн орчныг нь бас сайжруулаад хараат бус байдлыг нь бол бэхжүүлээд явах ийм шаардлага байна. Одоо хүн хүч, хөрөнгө санхүү, тэгээд барилга байшин гээд зөндөө олон юм байна л даа. Аймагт байж байгаа төрийн аудитын газрууд бол Аймгийн ЗДТГ-ын байран дотор л байрлаж байгаа. Тэгэхдээ бид нар хараат бусаар хяналт тавь гэдэг ийм шаардлага тавьдаг. Хуулийн заалт зарчим ийм. Тэгэхээрээ энэ бүгдийг бас тал талаас нь анхаарах зүйлүүд байгаа. Тэгээд энэ ажил амьдралын бас зарим юуг нь шийдэхэд Төсвийн байнгын хороо бас анхаарал тавьж, манай хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор бид бас ажлын хэсэг гаргаад ингээд ажиллаж байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Юуны өмнө бас та бүхнээс хүлцэл өчье. Өнөөдөр бас нэлээн ачаалалтай

ажиллалаа. Хаврын чуулганы төгсгөл рүү дөхөж байгаа учраас Улсын Их Хурал болоод Байнгын хороод бас нэлээн өндөр ачаалалтай ажиллаж байна. Өнөөдөр бас өдөр хуралдах байсан хурал маань оройтож хуралдаж байна.

Ингээд төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланг бас хэлэлцэж дууслаа. Төрийн аудитын байгууллагад би бас хувь хүнийхээ үүднээс 2023 оных нь үйл ажиллагааг нь дүгнэж хэлэхэд бол хууль тогтоох байгууллага буюу Улсын Их Хурлыг энэ хараат бус, үнэн зөв, яг хяналтынхаа үүргээ хэрэгжүүлэх хүрээнд бол хуулийн хүрээнд заагдсан үндсэн үүргээ бол бас би төрийн аудитын байгууллагыг бол амжилттай хэрэгжүүлж ажиллаж байна гэдгийг би бас онцлон хэлэх байна.

Тэр дундаа бид бүхний хувьд бас өнгөрсөн 2022, 2023 онууд бол нэлээн өндөр ачаалалтай байсан. Иргэдийн өмнө болоод мөн одоо нийгмийн өмнө хүлээсэн үүргүүдээ бас нэр төл төртэй биелүүлж чадсан гэж би бас дүгнэж үзэж байгаа. Тэр дундаа Улсын Их Хурал болоод Төсвийн байнгын хороотой маш олон шинэчлэлийн хүрээнд хамтарч ажилласан. Олон эерэг нааштай ахиц дэвшилүүд бол гарсан гэдгийг бас манай Байнгын хорооны гишүүд маань бас онцолж хэлж байна. Эргээд зөвхөн хэд хэдэн жишээг бас нэг дурдаж хэлье гэж бодож байгаа юм. 2023 онтой холбоотойгоор нийгмийн хариуцлага шаардсан эдийн засгийн олон асуудлуудаар хөндлөнгийн аудитыг хийж гүйцэтгэсэн байгаа. Та бүхний бас сая тайлан дээр гарсан байна. Төрийн аудитын байгууллага 2023 оныхоо санхүүгийн тайлангаар үндсэндээ 17,7 их наяд төгрөгийн, 7,7 их наяд төгрөгийн зөрчлийг илрүүлсэн байна. Үүн дотроосоо бол 6,8 их наяд төгрөгийн алдааг залруулсан байна. Ингээд төрийн аудитын байгууллага үндсэндээ бараг 10 мянга гаруй зөвлөмжийг бол гаргасан байна. Үүн дотроосоо 6,3 их наяд

төгрөгийн албан шаардлагуудыг бол холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болоод байгууллагуудад хүргүүлсэн байна. Энэ дотроос 242,2 тэрбум төгрөгийн төлбөрийн актуудыг тогтоожээ. Тэгэхээр энэ бол та бүхний ард байгаа Үндэсний Аудитын газар, албан хаагчид, мөн тэр дундаа хөдөө орон нутагт ажиллаж байгаа албан хаагчид, та бүхний салбар нэгжүүд, нийт аудитын байгууллагын мэргэжилтнүүдийн хийсэн бүтэн жилийн үр дүн гэж хэлэх байх. Энэ болбол бага дүн биш.

Нэг талдаа бас нийгмээс хариуцлага шаардсан олон нийтээс бас хариу хүлээсэн энэ хариуцлагатай ажлуудыг бас нэр төртэй биелүүлж байна гэж энэ дүнгээр бол дүгнэж үзэж болох байх гэж харж байгаа. Эдгээр аудитын байгууллагаас хийсэн залруулгын үр дүнд бол магадгүй манайхнаас тооцож үзсэнээр хүлээн зөвшөөрөгдсөн үр дүн нь 1,1 их наяд төгрөг буюу санхүүжилтийн төгрөг тутамд бий болсон үр өгөөж бол 38,4 төгрөгөөр хийгдсэн байна гэсэн ийм дүгнэлтийг гаргасан байгаа. Тэгэхээр энэ бол бодитоор бас ямар хэмжээний ачааллыг авч, яаж ажилласан юм бэ гэдгийн бодит илэрхийлэл байх гэж харж байгаа. Тэгэхээр зөвхөн Үндсэн хуулийн хүрээнд хүлээсэн үүргээ хяналтынхаа үүргээ гүйцэтгэхээс гадна Төсвийн байнгын хорооноос санаачилж хэрэгжүүлсэн олон олон шинэчлэлийн хүрээнд бас манай төрийн аудитын байгууллагууд бол хамтарч ажиллаж санал, зөвлөмж, өөрсдийнх нь бас саналаа хүргэж ажилласан. Тэр дундаа Улсын Их Хурлаас томилогддог болон Улсын Их Хурлын харьяа байгууллагууд дундаас үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт рүү шилжих шилжилтийг хамгийн түрүүнд манлайлж бас ганцаараа эхлүүлсэн байгаад байгаа. Үүний араас манай ШЕЗ болоод шүүх байгууллагууд бол бас шилжсэн. Цааш цаашдаа бүх төсвийн байгууллагууд шилжих шилжилтийн эхлэлийг тавьсан

байна гэж бас дүгнэж үзэхээр байгаа. Энэ 2023 онд бид бүхэн цаашдаа зөвхөн гүйцэтгэлд суурилсан санхүүжилт биш, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, санхүүжилт рүү шилжих гол үндэс суурь бол бас эндээс эхэлж байна гэж бол харах байна.

Төсвийн байнгын хороо өнгөрсөн жил эхлүүлсэн гол үндсэн шинэчлэлийн асуудал болох төсвийн сахилга баттай холбоотой, төсвийн хяналттай холбоотой, олон нийтийн оролцоо болоод хяналтыг бэхжүүлэхтэй холбоотой төсвийн шинэчлэлийн багц хуулиудыг бас баталсан. Энэ хүрээнд манай олон нийтийн хяналт оролцоо төсвийн төлөвлөлттэй холбоотойгоор манай аудитын байгууллага маань нэг шат ахисан гэж бол үзэж байгаа.

Төрийн аудитын байгууллага үндсэндээ бол олон нийтээс санал авдаг, төсвийнхөө сэдэв дээр олон нийтийн оролцоотойгоор төсвийнхөө сэдвийг төсөвлөдөг, аудитынхаа сэдвийг төлөвлөдөг болсон. Энэ бол нэг талдаа бас бид бүхэн олон нийтийн хяналт оролцоог сайжруулж, аудитын байгууллага олон нийттэйгээ хамтарч хяналтаа тогтоох үндэс суурийг бас засаглалыг бий болгож байна гэж бас харж байгаа. Тэгээд энэ бол нэг талдаа бид бүхний хүрээнд аудитын байгууллагын хяналтыг бэхжүүлэхтэй холбогдсон гол үндсэн суурь ажил байна гэж харж байгаа.

Энэ жилээс эхлээд 9 сард төсвийн төсвүүд, төсвийн төсөл өргөн баригдана. Улсын Их Хуралд. Анх удаагаа аудитын байгууллага төсвийн төсөл буюу төсвийн төлөвлөлт дээр аудит хийдэг болж байгаа. Эргээд 9 сарын 25-нд та бүхэн маань бас бүхэл бүтэн хуучин цаг хугацааны хайчинд орж ямар нэг байдлаар бүрэн мэдээлэл, төсвийн төсөлтэй үзэж танилцах эрх байхгүйгээр шахуу аудит хийдэг байсан энэ жишгийг бид нар энэ жилээс бүрэн дүүрэн халж, аудитын байгууллагын 9

сарын 1-ээс эхлээд 25-ны хооронд бүрэн дүүрэн, хангалттай хугацаанд аудит хийх эрхийг бол бас Улсын Их Хурлаас гаргаж ирж байгаа. Тэгэхээр энэ бол энэ бүх шинэчлэлийн хүрээнд аудитын байгууллага бол бас хамтарч ажиллаж, санал, санаачилгаа дэвшүүлж, өөрсдийнхөө санал, зөвлөмжөө манай Улсын Их Хуралд хүргүүлж, эдгээр шинэчлэлүүдийг хийхэд хамтарч ажиллаж байсанд би бас Байнгын хорооны даргын хувьд талархал илэрхийлэх ёстой гэж бодож байгаа.

Өнгөрсөн жилийн бас нэг зүйлийг орхичихсон байна. Өнгөрсөн жилийн илрүүлсэн 17,7 их наядын зөрчилтэй холбогдуулаад та бүхний гарган тавьсан 40 гаруй төсвийн ерөнхийлөн болон цууд захирагч нарт зөрчлийг арилгах шийдвэр болоод тодорхой хариуцлага тооцох шийдвэрийг Улсын Их Хурлаас гаргасан байгаа. Улсын Их Хурал та бүхний хийсэн аудитын тайлан, аудитын гүйцэтгэл болоод зөвлөмж, албан шаардлагатай холбогдуулж, холбогдох төсвийн захирагч нар, эдгээр зөвлөмжийн мөрөөр, актын мөрөөр, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг зайлшгүй хэрэгжүүлэх, ингээд зөрчлийг арилгах шийдвэрийг бол Улсын Их Хурал бол гаргасан байгаа. Хариуцлага тооцсон шийдвэрүүд гарсан байгаа. Тэгэхээр энэ бол цаашид бас бид бүхний хийж хэрэгжүүлж байгаа ажил, та бүхний ажлын үр дүн, бодит ажлын үр дүн гарч байгаагийн илэрхийлэл байх гэж болбол үзэж байгаа.

Би тэгэхээр та бүхний 2023 оны ажлын тайланг бол бас нэр төртэйгөөр, амжилттай биелүүлсэн байна гэж болбол дүгнэж үзэх байна.

Тэгээд 1 зүйлийг бас онцолж хэлье. Энэ бүх ажлуудыг гар бие гүйцэтгэхэд ажлын хэрэг болгож чадсан 2023 онд танай байгууллагыг бас толгойлж байсан Монгол улсын ерөнхий аудитораар ажиллаж байсан Занданбат

даргыг би бас онцгойлон дурдах ёстой. Тэгээд энэ хүнд бас талархал илэрхийлэх ёстой. Шинэ удирдлага Загджав дарга ерөнхий аудиторын албан үүргийг түр гүйцэтгэж байна. Та бүхэн одоо ажиллаж байгаа удирдлагууд, мөн өмнөх удирдлагынхаа хийж хэрэгжүүлж байсан санал санаачилга, мөн энэ шинэчлэлүүдийг бол цааши нь үргэлжлүүлэх ёстой. Цаашид бид бүхний өмнө хийх ажлууд бас зөндөө байна. Эргээд аудитын байгууллагын шинэчлэлийг, дотоод аудитын хяналтыг сайжруулах чиглэлээр бол бодитой үр дүнгүүд бас хийгдэх шинэчлэлүүдийг хийх үр дүнгүүд бол хүлээгдэж байгаа гэдгийг эцэст нь онцлон хэлэх байна.

Ингээд нийт аудитын байгууллагын нийт ажилчид, албан хаагч нар, удирдлагууд та бүхэнд ажлын амжилтыг хүсье.

2023 оны төрийн аудитын байгууллагын ажлын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа. Баярлалаа та бүхэнд.

Ингээд дараа нь хэлэлцэгдэхээр байгаа 2 асуудал байгаа. Энэ 2 асуудлыг ирэх 7 хоногийн 2 дахь өдрийн Төсвийн байнгын хорооны дараагийн хуралдаан хүртэл хойшлуулж байна.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг нэмэгдье.

Ингээд Байнгын хорооны гишүүд болоод байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

19.42 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ